

АГУУЛГА

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	4
2.1 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал	4
БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	6
3.1 Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ	6
3.2 Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл.....	8
3.3 Төслөөс усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ	9
3.4 Уурхайн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөлөл	9
3.6 Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл	11
БҮЛЭГ IV. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ	13
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ	13
БҮЛЭГ V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	14
5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зөвлөмж	14
5.2 Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зөвлөмж	15
5.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	16
5.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	16
5.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	17
5.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж	18
БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	22
БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	24
БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	26
БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	28
БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	29
БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ	30

БҮЛЭГ I. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

Төслийн дугаар:	2024/ӨМ-85
Төслийн нэр:	Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Зүүн цагаан хошуу” нэртэй төмрийн хүдрийн ордыг ил аргаар ашиглах төсөл
Төсөл хэрэгжүүлэгч:	“Эрдэнэмайнинг Үйлс” ХХК нь Монгол улсын 9019079090 тоот бүртгэлийн дугаар бүхий аж ахуйн нэгжийн гэрчилгээтэй.
Мэйл хаяг:	erdenemininguils@gmail.com
Тусгай зөвшөөрлийн дугаар:	MV-009515
Талбайн хэмжээ:	211 га
Төсөл хэрэгжүүлэгчийн тусгай зөвшөөрөл:	АМГТХЭГ-ын ГУУКА-аас 2007 оны 02-р сарын 22-ны өдөр Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Зүүн цагаан хошуу” нэртэй газар, ашигт малтмалын тухай хуулийн 26 дугаар зүйлийг үндэслэн MV-009515 тоот 210.84 гектар талбай бүхий ашигт малтмал ашиглах, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайг “Анхай Интернэшнл” ХХК-д олгосон байна. “Анхай Интернэшнл” ХХК-ийн Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт орших “Зүүн цагаан хошуу” нэртэй MV-009515 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.2-т заасны дагуу Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах ажлын албаны 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн “Өмчлөх эрх шилжүүлэх тухай” №01 дугаар тогтоол, мөн албаны 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 1/6803 тоот бичгийг тус тус үндэслэн АМГТГ-ын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 131 дүгээр шийдвэрээр ашигт малтмал ашиглалтын MV-009515 тоот тусгай зөвшөөрлийг “Эрдэнэмайнинг Үйлс” ХХК-д шилжүүлсэн байна.
Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 11-р хороо, зайсан, Хатантуул хотхон, 35 тоот, Утас:89102202

1.2 Төслийн талбайн байршил


Ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт байрлах бөгөөд Улаанбаатар хотоос баруун урд зүгт 170 км-т, Бага хангай, Мааньт өртөөнөөс баруун хойд зүгт тус тус 70-65 км, Баянжаргалан сумаас хойд зүгт 15 км-т дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн районд байрлана.

“Зүүн цагаан хошуу” нэртэй орд нь ашигт малтмал ашиглах MV-009515 тоот тусгай зөвшөөрөлтэй 211 га талбайтай.

Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийн солбицлын цэгүүдийг доорх хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №1 Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн солбицол

№	Зүүн уртраг			Хойд өргөрөг		
	градус	минут	секунд	градус	минут	секунд
1	108	12	49.54	47	17	17.72
2	108	11	51.54	47	17	17.72
3	108	11	51.54	47	18	13.72
4	108	12	49.54	47	18	13.72



Зураг № 1 “Зүүн цагаан хошуу” нэртэй талбайн байршилын тойм зураг




Зураг № 2 Төслийн талбайн сансарын зураг



Зураг № 3 Уурхай орчмын харагдах байдал

БҮЛЭГ II. ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1 Орон нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдал



“Зүүн цагаан хошуу” нэртэй төмрийн хүдрийн уурхай нь Улаанбаатар-Чойр-Замын-Үүд чиглэлийн гол төмөр зам, засмал зам, өндөр хүчдэлийн шугамаар холбогдсон нь дэд бүтцийн таатай нөхцөлд байна. Тус бүс нутагт Гэдгэр хангайн төмрийн хүдрийн уурхай, уг ордоос баруун урт зүгт 20 км зайд оршино.

Бөөрөлжүүтийн хөндийд олон тооны уурхайнууд ажиллаж эхлээд байна. Уурхай нь Баянжаргалан сумаас өндөр хүчдэлийн шугамд холбогдсон байна. Энэ мужийн аж ахуйн гол чухал салбар нь мал аж ахуй бөгөөд хонь, бод мал болон бусад төрлийн мал малладаг. Үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрийн газрууд, Баянжаргалан сум нь төвлөрсөн эрчим хүчний сүлжээнд холбогдсон. Газар тариалангийн аж ахуй бага хэмжээгээр хөгжсөн. Хүн амын нягтрал 1 км² -т 1-2.0 хүн ноогдож байдаг. Газар дээр нь ажиллах хүч авах боломжтой. Тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, барилгын болон модон материалуудыг Улаанбаатар хотоос, ШТМ-ыг Баянжаргалан сумаас, нүүрсийг Багануурын уурхайгаас, хүнсний зүйлийг Улаанбаатар болон Баянжаргалан сумаас тус тус зөөвөрлөн хангах боломжтой.

2.2 Байгаль орчны төлөв байдал:


Физик-газар зүй: Уг орд нь намхан хэлхээ уулс, уулс хоорондын хөндий тэдгээрийн хооронд сунасан жижиг толгодоос бүрдэнэ. Гадаргуугийн бүтэц нь өргөрөгийн дагуу буюу ерөнхийдөө зүүн хойшоо сунасан толгодорхог рельефтэй. Хамгийн өндөр цэг нь (орд газраас 3.У. 7.2 км-т орших) д.т.дээш 1576.60 м өндөр Жаргалант уул. Хамгийн нам цэг нь орд газраас БХ зүгт ойролцоогоор 15 км-т байрлах 1351.3 м өндөржилттэй Гүндгэн нуурын хөндий. Дундаж өндөр: д.т.д. 1500 м. Орд газрын баруун болон зүүн талаар 1-2 км өргөнтэй хөндий үргэлжилнэ. Уулын энгэр, хажуу нь 60° хүртэл огцом эгц налуу үүсгэх ба дунджаар 35°-40° налуутай байна. Уулсын өндөрлөг нь дунджаар 20-50 м, заримдаа 80-100 м байна.

Уур амьсгал: Эх газрын эрс тэс хуурай уур амьсгалтай. Гол төлөв гантай байх тохиолдол байдаг ба заримдаа энэ байдал удаан хугацаагаар үргэлжилнэ. Хавар агаарын дулаан 10-аас 20°C хүрэх ба цаг агаар их хувьсамтгай. Улирлын энэ үед шороон шуурга шуурах бөгөөд заримдаа салхины хурд 25-30 м/сек хүрнэ. Жилд унах хур тунадасны дундаж хэмжээ 205-310 мм. Жилийн туршид жигд бус хэмжээгээр унадаг. Ихэнх хур тунадас нь зуны улиралд ялангуяа 7, 8-р сард, заримдаа 6-р сард бороо байдлаар ордог. Өвлийн улиралд харьцангуй бага, нийт хур тунадасны 15-20% унадаг. Цасан бүрхэвч бага зузаантай үүсэх ба тал газар 10-15 см-ээс, уулархаг газраа 0.5 м-ээс хэтэрдэггүй байна. Цасан бүрхэвчийн зузаан бага учир хөрс 2.5-3.0 м хүртэл гүн хөлддөг. Зун цаг агаар нэлээд тогтвортой болж ирнэ. Ихэнхдээ хуурай халуун уур амьсгалтай байна. Агаарын температур 20°-аас 25°C, ховор тохиолдолд +35° аас +37°C хүрдэг. Улирлын эхэнд гол төлөв хүчтэй салхилна. Гол төлөв долоодугаар сарын эцэс, наймдугаар сарын дундуур хур бороо орно. Намар цаг агаар нэлээд тогтвортой байдаг улирал юм. Агаарын дулаан -10 аас 25°C, салхитай, хур тунадас багатай байдаг. Өвөл нь хуурай хүйтэн, 1-р сард дунджаар -15 аас -25°C, ховор тохиолдолд -30°C доош хүйтэрнэ. Салхилах нь бага. Цас бага хэмжээгээр унана.

Хүн ам зүй: Хүн ам нь Баянжаргалан сумын төвд голлон суурьшдаг. Хүн амын нягтаршил дунд зэрэг, 1 км² талбайд 0.1-5 хүн суудаг. Халх ястан голчлон мал аж ахуй эрхлэн нүүдлийн байдлаар амьдардаг ба Багануур хотод уурхайчид голчлон, сумын төвүүдэд жижиг аж ахуй эрхлэгчид амьдардаг. Мөн гар аргаар ашигт малтмал олборлох явдал өргөн бий. Нялгын хүрэн нүүрсний сав газрын баруун хойд хэсэгт орших Цайдам нуурын ордоос гадна Багануур, Төгрөг, Мааньт зэрэг 6 орд тогтоогдсоноос одоогийн байдлаар Багануурын ордыг 1978 оноос ашиглаж эхэлсэн. Төгрөг нуурын орд дээр хэд хэдэн компани хайгуулын ажил явуулж, шахмал түлш, шингэрүүлсэн хий үйлдвэрлэх туршилт хийгдэж байна. Хүн амын гол хөдөлмөр нь мал аж ахуй. Сумын төвд амьдардаг хүмүүс улсын болон хувийн аж ахуй эрхэлдэг. Захиргаа, эмнэлэг, сургууль, холбоо зэрэг улсын төсвийн байгууллага ажиллахаас гадна хувийн хэвшлийн компаниуд худалдаа үйлчилгээ эрхэлдэг. Аймаг хот, сумын хооронд автотээвэр, холбоо харилцаа сайн хөгжиж байгаа нутаг юм. Өндөр хүчдэлийн шугамд холбогдсон. Сумын төвүүдэд үндэсний болон гадаадын телевизийн нэвтрүүлэг үзэх боломжтой, үүрэн телефоны сүлжээтэй, Улаанбаатар хотоос Баян сум хүртэл хатуу хучилттай замтай байна.

Ургамал зүй: Ургамлын бүрхүүл сул хөгжсөн бөгөөд ихэнхдээ хөндий болон нам дор газруудад төвлөрөн өвс ургамал ургасан байдаг. Зонхилох ургамал нь өвслөг, бутлаг ургамлууд юм. Модны төрлөөс хөндийнүүдийн эрэг дагуу бургас ургах ба зарим хэсэгт шигүү ургасан байдаг.

Ан амьтан: Амьтны ертөнц нь нэлээд олон янз төрөл бөгөөд харин тоо толгой нь цөөн. Гол төлөв туурайтан, мэрэгчид болон бусад амьтад энд нутагладаг. Махчин амьтадаас чоно, үнэг, хярс, мануул тохиолдох ба жигүүртнээс хэрээ, ууль, бүргэд, болжмор нутагладаг.



Зураг № 4 Монгол орны ан амьтны зураг

БҮЛЭГ III. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг үнэлэхдээ өмнөх шатанд тодорхойлогдсон болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүд, түүний үйлчлэлд өртөх нутаг дэвсгэрийн байгаль орчин, нутгийн оршин суугчид, түүх, соёлын өвд бий болох сөрөг үр дагавар, түүний эрчим, цар хүрээ, шууд болон шууд бус нөлөөллүүд, болзошгүй нөлөөллийг Монгол улсын хууль тогтоомжид заасан болон олон улсын нийтлэг аргуудыг ашиглан үнэлсэн байна.

3.1 Төслийн байршилтай холбогдох нөлөөлөл, үнэлгээ

“Эрдэнэмайнинг Үйлс” ХХК хэрэгжүүлэх төслийн байршил, техник-технологийн шийдэл төлөвлөлт болон төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдсон болзошгүй нөлөөллийг тодруулахын тулд магадлан жагсаах аргыг хэрэглэн үр дүнг нь доорх хүснэгтэд илэрхийлэв.

Хүснэгт № 2 Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлах жагсаалт

Байгаль орчны асуудал	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
		Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал				
Голын голдирылыг эвдэж, өөрчлөх	х			
Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	х			
Ой модыг огтлох, гэмтээх асуудал	х			

Түүх соёлын дурсгалт газар, археологи-палентлогийн олдвор	х			
Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	х			
Булаг, шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	х			
2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал				
Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцэх эсэх, түүхий эдийг олдворлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			х	
Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн				х
Эрдсийг боловсруулах технологийн үйл ажиллагааны үед ус, агаар, хөрс бохирдох, хатуу хог хаягдал болон их дуу чимээ гарах		х		
Тусгай анхаарал тавих шаардлагатай хорт хий, тоос, утаа гардаг эсэх	х			
Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх		х		
3. Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай				
Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	х			
Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараа хөрсний элэгдэл, эвдрэл		х		
Үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх, халдварт өвчин гарах нөхцөл		х		
4. Төсөл хэрэгжүүлэх үеийн байгаль орчны асуудал				
Төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой, шаардлага хангасан эсэх				х
Мэргэжлээс шалтгаалах өвчин болон аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, санхүүжилт бодитой эсэх				х
Хөрсний эвдрэл, элэгдлийг бууруулах, орчныг тохижуулах асуудал төлөвлөгөөнд хэрхэн тусгагдсан (хөрсжүүлэх, ургамал тарих, зүлэгжүүлэх, талбайн усалгаа)				х
Эрдэс баялгийг авч ашиглах зэргээс шалтгаалж хөрсөнд ус нэвчих, гүний ус бохирдох, улмаар хөрсний усны горимд эсрэгээр нөлөөлөх	х			
Газар ашиглалтад хохирол учруулах, үйл ажиллагаа явуулах үед газар тэгшлэх, буцааж булаах ажлыг хамгийн бага байлгах нь бусад зорилгод ашигтай байж болох, хөрш зэргэлдээх газар ашиглалтад гэмтэл учруулахгүй байх зэрэг асуудал төсөлд тусгагдсан эсэх			х	
Шуурхайн хяналтын асуудал (төсөлд шуурхайн хяналтын хугацаа, зардал тусгагдсан эсэх)		х		
Төслийн хэрэгжүүлэх үеийн инженерийн болон санхүүгийн боломжийн талаарх асуудал				х
5. Төслийн ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд (бодлогын чанартай асуудлууд)				
Төслийн хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг ашиглахгүй орхигдуулах	х			
Төслийн техник, технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх асуудал				х
Дүн	10	5	2	6

Төслийн байршил, шийдэл, төлөвлөлт болон хэрэгжүүлэхтэй холбогдсон болзошгүй нөлөөллийн магадлан жагсаах аргаар үнэлсэн үнэлгээгээр

1. Голын голдирлыг өөрчлөх, хүн амыг нүүлгэн шилжүүлэх, ой модыг огтлох гэмтээх зэрэг бусад 10 асуудлаар ямар нэгэн нөлөөлөл үзүүлэхгүй байна.

2. Уурхайн үйл ажиллагааны үед гарах дуу чимээ, үйлдвэрлэлийн осол аваар, хортой нөхцөл үүсэх гэх мэт 5 асуудлаар бага хэмжээгээр нөлөөлөл үзүүлнэ.
3. Дунд зэрэг өртөх 2 асуудлаар нөлөөлөлтэй байна.
4. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал, төслийн үйл ажиллагааны болон ашиглалтын чанарын талаарх төлөвлөгөө, санхүүжилт хэр зэрэг бодитой шаардлага хангасан зэрэг 6 асуудлаар төслөөс их нөлөөлөлтэй байна.

Эдгээр асуудлуудад анхаарал хандуулах тодорхой үе шатанд зохих урьдчилан сэргийлэх ажлуудыг авч байх нь зүйтэй.

3.2 Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл

Эдийн засгийн үр өгөөж, үзүүлэлт

Эдийн засгийн тооцоонд дараах зардлын элементүүдийг тусган тус тусад нь тооцоолон нэгтгэн дүгнэж эдийн засгийн үр ашгийг, гаргаж байгаа бүтээгдэхүүний борлуулалтын зах зээлийн үнийн өөрчлөлтөөс хамаарч ирээдүйн үнэ цэнэ болон хөрөнгө оруулалтын ашгийн дотоод өгөөмж хэрхэн өөрчлөгдөж байгаагаар нь тодорхойлсон.

“Зүүн цагаан хошуу” нэртэй төмрийн хүдрийн ордын эдийн засгийн тооцоог гүйцэтгэхдээ хүдэр олборлох, ангилан ялгах ажиллагааны өөрийн өртгийн тооцоог гүйцэтгэн нэгтгэх замаар бүтээгдэхүүний эцсийн үр дүнгээр ашгийн түвшинг тооцоолов.

Ажиллагсдын эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Үйлдвэрийн технологийн дамжлагуудын онцлогоос шалтгаалан гарах тоосжилт, ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдал, тоос шороо, чимээ шуугиан, бичил орчны температур, чийгшил, гэрэлтүүлэг, агааржуулалтын өөрчлөлт, технологийн үйл ажиллагаанаас үүсэх тоосны 10 микроноос бага хэмжээтэй хэсгүүд нь хүний уушги болон амьсгалын замын эрхтэнийг өвчлүүлэх гол эх үүсвэр болно. Удаан хугацаанд сөрөг нөлөөтэй орчинд ажилласнаас ажилчдын анхаарал сарних, осолд өртөх, элдэв өвчинд нэрвэгдэж, хөдөлмөрийн чадвараа түр буюу бүр мөсөн алдах зэргээр осол аюултай үр дагаврыг үзүүлнэ.

Иймд физикийн хүчин зүйлүүдийг зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, ялангуяа тоосжилт, дуу чимээ, химийн бодис хэрэглэдэг, доргилт ихтэй үйл ажиллагаанд түүнийг сулруулсан ХХАА-ны хувцас хэрэглэлээр хангахын зэрэгцээ мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллавал зохино. Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал, усны гэнэтийн аюул учирч болзошгүй.

Төслийг хэрэгжүүлэхэд ажиллах хүчийг төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн оршин суугчдаас авч ажиллуулах, төсөл хэрэгжиж дууссаны дараа уурхайд ажиллаж байсан хүмүүсийн ажил эрхлэлтийн асуудлыг шийдвэрлэхгүй орхивол ядуурал, ажилгүйдэл нэмэгдэнэ. Мөн үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх зэрэг нийгэм эдийн засгийн олон сөрөг нөлөөлөл үүснэ.

Уг төсөл хэрэгжих явцад ажлын байрны тоо нэмэгдсэнээр нийгэм эдийн засгийн хөгжилд эерэг нөлөөг үзүүлнэ.

3.3 Төслөөс усны нөөц, чанарт нөлөөлөх байдал, үнэлгээ

Төслийн талбай нь ус зүйн хувьд Төв азийн гадагш урсгалгүй ай сав, Умард говийн гүвээт-Халхын дундад талын сав газарт багтана.

Судалгааны арга зүй:

Хээрийн судалгааны үеэр **холбогдох аргачлалын дагуу төслийн талбайд байрлах гүний худгаас усны 1 сорьц авч** 2023 оны 10-р сарын 09-13-ний өдөр “Грийн лаб” ХХК-ийн хөрс, ус судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.

Хээрийн судалгаагаар дараах хэмжилт дээжлэлтийг хийсэн болно. Үүнд:

- Бичиглэл хийсэн он, сар өдөр;
 - Хэмжилт, дээжлэлт хийсэн солбицол (WGS 1984 UTM Zone 48N);
 - Хээрийн судалгааны үед дээж авах даа MNS 5667-11:2000 (Гүний уснаас дээж авах зөвлөмж) стандартын дагуу авсан. Үүнд:
- Дээжлэлтийг хийхдээ эхлээд тусгай зориулалтын палиэтилен дээжний саваа 3 удаа тухайн дээжлэлт хийх гэж байгаа усаар зайлна;
 - Үүний дараа дээжний саваа дээжээр бүрэн дүүргэж дээр нь агаар байх зайгүйгээр таглана;
 - Ингэснээр тээвэрлэлтийн үед сэгсрэгдэх, хийнүүдийн хоорондох харилцан үйлчлэлийг хязгаарлана. Тээвэрлэлтийн үед дээжүүдийг харанхуй, сэрүүн хайрцагт хадгалсан;
- Усны шинжилгээний үр дүнг MNS 0900:2018 (Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт) стандарттай харьцуулсан;

3.4 Уурхайн үйл ажиллагаанаас хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

Энэхүү лицензийн талбайд хэсэг нэгж бүрд уурхайлалтын явцад сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй хөрсний төрөл, тэдгээрийн эзлэх талбайн хэмжээг тооцов.

Уурхайлалтаас эвдрэх, шимт хөрсний болон хаягдлын овоолгод дарагдах хөрсийг ангилал тус бүрээр хэмжээг тодорхойлов.

Сөрөг нөлөөллүүд нь хөрсөнд эсвэл удаан хугацааны турш эсвэл байнга эргэж буцалтгүйгээр нөлөөлөх талтай бөгөөд ямар ч байсан тэдгээрийг уурхайн үйл ажиллагааны үед нөхөн сэргээлт хийх замаар багасах боломжтой. Эцсийн ерөнхий төлөвлөгөөнд үйлдвэр болон хаягдлын овоолгын ойр орчмын талбайд бүтээмж ихтэй бэлчээрийн ургамал тарих боломжгүйг харгалзан тэнд хэсэгчилсэн байдлаар хөрсний үе давхаргыг нөхөн сэргээх талаар зөвлөмж оруулсан болно.

Хүснэгт №3 1 Болзошгүй нөлөөлөл байгалийн хам бүрдэлтэй уялдах нь

№	Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Шимт хөрс хуулалт				х	
2	Хөрсний овоолго		х			
3	Машин механизмын шатахуун, тослох материал ил задгай асгарах			х		
4	Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдал			х		
5	Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай				х	

6	Уурхайн үйл ажиллагаанаас хөрсний үржил шимд нөлөөлөх				х	
	Нийт		1	2	2	
	Эзлэх хувь, %		20%	40%	40%	
Дүгнэлт - Нийт нөлөөллийн 20% нь бага, 40% нь дунд, 40% нь их гэсэн ангилалд багтаж байгаа тул барилгын чулуу олборлох уурхайн төслөөс тухайн нутгийн хөрсөн бүрхэвчинд нөлөөлөх нөлөөллийн зэргийг ИХ гэж дүгнэж байна.						

Төслийн талбай дахь ургамалжлын өнөөгийн төлөв байдал ба доройтол

Талбайн төрх байдал: Төв аймаг, Баянжаргалан сум, “Эрдэнэмайнинг” ХХК-ын уурхайн “Цагаан хошуу” төслийн тусгай зөвшөөрлийн талбайн ургамлан нөмрөгийн төрх байдлын хувьд уурхайн ашиглалтын улмаар ургаман нөмрөггүй болсон талбай **0.8** га (2.8%), бусад **0.8** га (2.8%) өвслөг угамалтай чулуутай болон цэвэр ургамлан нөмрөгтэй байна.

Талбайн төлөв байдал: Төслийн талбайн ургамлан нөмрөгийн өнөөгийн төлөв байдлын доройтлын зэргийг тогтоохдоо ургамлан нөмрөгт талхлагдлын заагуур ургамал хэдэн зүйл, хэрхэн ариантай ургасан байгаа болон “Бэлчээр газрын хөрсний элэгдэл, эвдрэл, ургамлын талхлагдлыг тодорхойлох” MNS5546:2005 стандартыг харгалзан доройтлын 3 зэрэгт ангилан үзэв. Үүнд:

- Хүчтэй доройтсон газар.** Тухайн талбайд жалга гуу дан хог ургамлаар дүүрсэн, энд тэнд үүсмэл бүлгэмдэл бий болсон, кэмп байгуулах зэрэг газар ашиглалтын явцад ургамлан нөмрөг газрын хөрснөөс арчигдсан, нийт 33.6 га га (13.74%) талбайг хүчтэй доройтолд хамруулав.
- Дунд доройтсон газар.** Зонхилогч ургамлын ариантай багасаад агь шарилж, лууль зэрэг ургамлууд арви ихтэй ургасан, MNS5546:2005 стандартын дагуу мал иддэг ургамлын эзлэх хувь 20-50% болсон, талхлагдлын заагуур ургамал 3-4 зүйл бөгөөд тэдгээр нь 31-50% эзэлдэг, ургацын буурал 41-60% болсон байвал дунд доройтсонд хамруулдаг.
- Сул доройтсон газар.** Үндсэн бүлгэмдлийн зонхилогч дэд зонхилогч нь бүлгэмдэлдээ үүрэгээ алдаагүй боловч MNS5546:2005 стандартын дагуу мал иддэг ургамлын эзлэх хувь 51% -иас бага болсон, талхлагдлын заагуур ургамал 2-4 зүйл бөгөөд тэдгээр нь 10-30% эзэлдэг, ургацын буурал 20-40% болсон байдаг.
- Доройтоогүй эрүүл хэвийн газар.** Ургамлан бүлгэмдлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүтээмжид өөрчлөлт ороогүй, унаган байдлаараа байгаа ургамлан нөмрөгийг эрүүл хэвийн гэх бөгөөд энд доройтоогүй газар алга байна.

Хүснэгт №4 Ургамлан нөмрөгийн төлөв байдал ба доройтол

№	Дээж	Талбайн хэмжээ, га	Ургамалжлын бичиглэл			
			Ургамлын тусгаг бүрхэц, %	Ургац, ц/га	Халцгай газрын хэмжээ, %	Доройтлын зэрэг
1	Хялгана-алаг өвст уулын хээр (50/ У-V-1-3)	177.4 га	60.0	3.04	27.0	Сул доройтсон
2	Хялгана-хиаг-шарилжит хээрийн бүлгэмдэлд (105a/ X-I-2-4)		71.2	4.322	25.0	Сул доройтсон

3	Дэрс-хялгана-хиаг-хог ургамалт жалгын нугын бүлгэмдэлд (221а/ Н-III-3-2)		-	3.9	34.0	Дунд зэрэг доройтсон
4	Ашиглалтанд өртөж эвдэрсэн талбай	33.6 га	-	-	-	Хүчтэй доройтсон

3.5 Төслөөс амьтны аймагт нөлөөлөх байдал, үнэлгээ

Уг төслийн үйл ажиллагаатай холбоотойгоор уурхай орчимд тохиолдох амьтны аймагт дараах байдлаар дам болон шууд нөлөөг үзүүлнэ.

- Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүн машин, техникийн төвлөрөл, хөдөлгөөн, дуу чимээ, доргио чичиргээ, тоосжилт, гэрлийн нөлөө зэргээс зарим хөхтний зүйл дайжих, тархац нутаг хумигдах, тэдгээрийн идэвхжил өөрчлөгдөх, идэш тэжээл хомсдох.
- Төсөл хэрэгжих талбайн ойр орчинд хөрс хуулалт, хүдэр олборлолт, тээвэрлэлт болон бусад газар шорооны ажлын явцад төслийн талбайд тэмдэглэгдсэн амьтад өдөр болон шөнийн цагаар тээврийн хэрэгсэлд дайрагдах, ялангуяа жижиг мэрэгч, мөлхөгч амьтад үргэн дайжих, амьдрах орчноо алдах, байршил тархалт өөрчлөгдөх.
- Уурхайн ажилчдын суурин, барилга байгууламж, хог хаягдлын цэгийн төвлөрөлтэй холбоотойгоор синантроп зүйлүүд барилга байгууламжид үүрлэх, хог хаягдлын индикатор зүйлүүдийн тоо толгой өсөх магадлалтай.
- Уурхайн үйл ажиллагаатай холбоотой нүх, цооног, усан сан бий болсноор мал, амьтад унаж үхэх, бэртэх
- Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, машин, механизмаас тос тослох материал алдагдах, мөн осол аваарын үед техникийн гаралтай бохирдуулагч хөрсөнд нэвчиж ургамалжилтад нөлөө үзүүлэх, бохирдуулах, бохирдсон ургамлыг идсэн мал амьтан хордох.
- Замын ажил, цахилгаан дамжуулах шугам барих, өргөтгөл хийх зэрэг барилгын ажлын үед мал, амьтдын бэлчээр, тархац нутаг түр зуур хомсдох.
- Төслийн үйл ажиллагаатай холбоотой аливаа нэгэн зүйл устаж, дайжиж алга болсонтой холбоотойгоор экологийн идэш тэжээлийн зохистой харилцаа алдагдах.
- Уурхайн ажилчдын суурин бий болж, хүн амын төвлөрөл нэмэгдэхийн хирээр хууль бус агнуур, ялангуяа цагаан зээр агнах магадлалтай.
- Хүний буруутай үйл ажиллагааны нөлөөнөөс гарах хээрийн түймэрт амьтад өртөх, амьдрах орчноо алдагдах.

3.6 Төслийн газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

Тус ордыг ашиглалтын тусгай зөвшөөрөл 211 га талбайг эзэмшдэг. Талбайн үржил шимт хэсгийг 20 см хүртэл зузаантайгаар хуулж тусгайлан хадгалах ба уурхайг ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэнэ.

Эдгээр газар ашиглалтын хэсгүүдэд ашиглалтын тодорхой хязгаарлалтуудыг тогтоож өгснөөр газар ашиглалтаас үүдэн гарах газрын гадаргын өөрчлөлт, газрын эвдрэл зэргийг хянах зохицуулах боломж бүрдэнэ.

Тус талбайн хувьд газрын гадаргын бага зэргийн эвдрэлтэй. Энэ нь бага хэмжээний талбайд гүнзгий ухаш, хайгуулын ажлын ул мөр, тээврийн хэрэгслийн мөр зэрэг эвдрэл үүссэн байдалтай байна.

Хүснэгт №5 Төслөөс газрын гадарга, хэвлийд үзүүлэх нөлөөлөл

№	Сөрөг нөлөөлөл	Үр дагаврын үнэлгээ				
		Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1	Ил уурхай, овоолго, зам бусад байгууламжуудаар газрын гадаргын хэлбэр дүрс өөрчлөгдөх				х	
2	Ил уурхай, овоолго, ангилан бутлах цех зэргийг байгуулахад газрын хэвлийг эвдэх				х	
3	Уурхайн хаягдал чулуулгийн овоолгоос геологи орчин, агаар, ус бохирдох		х			
4	Газрын хэвлийд үүсэх хоосон орон зай нь мал амьтанд аюултай байдал үүсэх			х		
5	Гадаад дотоод тээвэрлэлт хийх автозам			х		
6	Бутлах цех ажиллах, уурхайн суурингийн объектууд, бусад агуулах зэрэгт өртөх эдэлбэр газар ашиглалтаас хасагдах			х		
Дүгнэлт - Нийт нөлөөллийн 33.3 хувь нь их, 50 хувь нь дунд, 16.7 нь бага ангилалд багтаж байгааг үндэслэж тухайн төсөл орчны газарзүй, ландшафт, геологи орчинд газрын хэвлий, газрын гадаргад эрчимтэй нөлөөлөл үзүүлэхээр байна гэж үзэв. Дээрх нөлөөллүүд газрын гадаргын байгалийн төрх, геологи орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд өөрчлөлт үүсгэж, техноген ландшафтын элементүүдийг буй болгоно. Хаягдлын овоолго, ил уурхайн хоосон орон зай үүсгэн цаашид байгалийн анхны төрхтэйгөөр гүйцэд нөхөн сэргээгдэхгүй учраас барилгын чулуу олборлосон талбай нь эргэлт буцалтгүй өөрчлөгдөнө.						

3.7 Археологийн олдворууд ба түүх, соёлын дурсгалт зүйлс, тусгай хамгаалалттай газар нутагт үзүүлэх нөлөөлөл

Төсөл хэрэгжих орчны газрын ойролцоо түүх соёлын дурсгалт зүйлс одоогоор илрээгүй байгаа бөгөөд хэрвээ илэрвэл тэр даруйд холбогдох байгууллагад мэдээллэх үүрэгтэй.

Тус төслийн талбай нь улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутагтай давхцалгүй байна.

Дүнгүүдийг нэгтгэх нь байгаль орчинд нөлөөлөх гол нөлөөллүүдийг тодорхойлох, төслийн үйл ажиллагааны явцад өртөгдөх байгаль орчны болон нийгэм эдийн засгийн үнэт зүйлсүүд, түүн дэх нөлөөллийн цар хүрээг тогтооход чиглэгддэг.

Хүснэгт №6 Байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээний нэгтгэл

Байгаль орчны бүрдэл хэсгүүд	Нөлөөллийн үр дагаврын үнэлгээ				
	Маш бага буюу нөлөөгүй	Бага	Дунд	Их	Аюултай
1. Байгаль орчин					
Газрын гадарга, хэвлий	0	-1	-3	-2	0
Газрын гадарга ба газар доорх ус	-1	-2	0	0	0
Агаарын чанар	0	0	-3	-4	0
Хөрс	0	-1	-2	-3	0
Ургамал	0	-1	-1	-2	0
Амьтан	0	-1	-3	0	0
Нийт нөлөөллийн тоо	1	6	12	11	0

Эзлэх хувь	3.3	20	40	36.7	0
2. Нийгэм эдийн засгийн орчин					
Нутгийн оршин суугчид	0	0	+3	-1	0
Түүх соёлын дурсгал	0	0	0	0	0
Нийт нөлөөллийн тоо	0	0	3	1	0
Эзлэх хувь		0	75	25	0
Ерөнхий дүгнэлт	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 3.3 хувь нь маш бага буюу нөлөөгүй, 20 хувь нь бага, 40% нь дунд зэрэг, 36.7 хувь нь их байна. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдлын нийт нөлөөллийн 25 хувь нь их /эрэг/, 75 хувь нь дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна. Дээрх бүгдээс үзэхэд тус төсөл хэрэгжихэд байгаль орчинд болон нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл дунд зэрэг сөрөг нөлөөтэй байна.				

- Сөрөг нөлөө, + Эерэг нөлөө

БҮЛЭГ IV. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

"Эрдэнэмайнинг Үйлс" ХХК-ийн 2025 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө (БОХТ) нь уг төслийн үйл ажиллагааг эрхлэн явуулах бүхий л үе шатыг хамрах ба гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах арга хэмжээ буюу төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлэхэд оршино.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан БОМТөлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам, 2014 оны А-117 тоот тушаалын 4-р хавсралтаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах аргачлалыг тус тус баримтлан боловсруулж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хяналтын хуудсыг хөтөлбөрт хавсаргасан бөгөөд БОМТ-нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө ажил хийгдэхгүй болно.

2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний ажилд **13,126,000** төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримтлах арга зүй, стандарт, холбогдох эрх зүйн баримт бичгийн заалт, зардлын задаргааг тусгав.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилт:

1. Агаарын чанар, хөрсөн бүрхэвч, гүний усанд төслийн үйл ажиллагаанаас үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг багасгах, бууруулах, арга хэмжээг тогтоох,
2. Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх явцад мөрдөх эрх зүйн баримт бичиг, стандартыг баримтлах
3. Шаардлагатай хөрөнгө, зардлыг урьдчилсан байдлаар тооцож тодорхойлох
4. Биологийн нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах ажил, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламж байгуулах ажлыг чанартай хийж гүйцэтгэх зэрэг орно.

БҮЛЭГ V.СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ

№	Төлөвлөгөөний төрөл	Зардлын дүн
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	3,800,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	3,750,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	800,000
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,200,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,576,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	1,000,000
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	1,000,000
Төлөвлөгөөний нийт зардал		13,126,000

АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөллүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлий, хөрс, ургамал, агаар орчин бохирдох, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө гэж үзсэн байна. 2024 оны “Саут Воли” ХХК нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг хийлгүүлсэн байна. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зөвлөмжийг өгч байна.

5.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зөвлөмж

- Цаг уурын мэдээг тогтмол авч салхины чиглэлд хяналт тавьж ажиллах
- Үржил шимт хөрс болон үндсэн хөрсний овоолгыг тохиромжтой газар байрлуулах, салхинд хийсэж тоосжилт үүсгэхээс сэргийлэх арга хэмжээ авах
- Хаягдлын овоолгоос тоосжилт ихээр үүсэх магадлалтай тул гадна талаар хашаа барих, овоолгын гадаргууг дагтаршуулах арга хэмжээ авах
- Хүдэр бутлах төхөөрөмжид нэмэлтээр тоос баригч суурилуулах, хаалт хийх жигдрүүлэлтийн хэсгийг битүү орчинд явуулах
- Төслийн түүхий эд, хаягдал, баяжмал зэргийн талбайд ТЭЗҮ-ийн зураг төслийн дагуу байршуулж бусад эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх
- Төмрийн хүдэр баяжуулалтаас гарах хаягдлын овоолгын талбайн гадуур 3-5 м өндөр хаягдал салхинд хийсэхээс хамгаалах хашаа, наалт хийх
- Үйлдвэрийн зонхилох салхины доод талд болон үйлдвэрийн орчинд агаарын чанарын мониторингийн цэг байгуулан тогтмол хэмжилт хийж үр дүнд анализ хийж байх
- Уурхайн суурингийн дулаан хангамжийг өвлийн улиралд нам даралтын зуух ашиглан хангах тохиолдолд агаарт гарах хийн хаягдлыг бууруулахад янданг өндөр хий, янданд утаа шүүгч суурилуулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, дулаан

хангамжийг цахилгааны хүчин чадалд нийцүүлэн аль болох цахилгаанаар хангахыг зорих

- Машин механизмын утаанаас агаарт ялгарах хорт хийн хэмжээг бууруулах арга хэмжээ авах, ашиглаж буй машин техникт үзлэг, засвар үйлчилгээг тогтмол хийх шаардлагатай хяналтыг үйл ажиллагаандаа хэвшүүлэх байдлаар хэрэгжүүлэх
- Тээврийн хэрэгсэл болон машин механизмын хөдөлгүүрүүдийн тохиргоо оношилгоо үйлчилгээг тогтмол, чанартай хийж, тос маслыг тогтмол солих ба хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг (MNS 4804:99) стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах
- Усны машин ашиглан тоосжилт үүсэх зам, талбайнуудыг дулааны улиралд услах, чийглэх, замыг дагтаршуулах.
- Хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, хурдны хязгаарлалтыг анхааруулсан замын тэмдэг, тэмдэглэгээ байршуулна
- Үйлдвэрийн үйл ажиллагаанаас ашиглалтын явцад машин техникийг тогтоосон замаар явуулж, ашиглахаа больсон замыг хааж, нөхөн сэргээх
- Бие засах газар, хатуу хог хаягдлыг хадгалах сав, шингэн хаягдлын цооног зэрэгт мэргэжлийн байгууллагаар ариутгал хийлгэх, хатуу хаягдлыг цэг байгуулах, дулааны улиралд тогтмол ариутгал халдваргүйтгэл хийж байх

5.2 Газрын гадарга, газрын хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, зөвлөмж

- Төслийн үйл ажиллагааг ТЭЗҮ-д тусгасан хугацаанд, ТЭЗҮ-ийн хүчин чадлын хүрээнд хэрэгжүүлж дуусгах,
- Төсөл хэрэгжүүлэгч нь “Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт” MNS 5916:2008 стандартын дагуу хуулан авч хадгалах, нөхөн сэргээлтэд стандартын дагуу ашиглах
- Газрын гадаргын ландшафтыг орны байгалийн нөхцөлд нийцүүлэн хэлбэршүүлэх
- Үйлдвэрийн ажилчид болон хүдэр тээвэрлэх үед олон салаа зам үүсгэж зорчихгүй байх, нэгдсэн зам маршрутын дагуу тэмдэг тэмдэглэгээ байршуулах
- Шатах тослох материалыг хадгалах, түгээх байгууламж орчимд аюулгүйн бүс байгуулах, тэмдэг тэмдэглэгээг сайжруулах
- Хаягдлын овоолгыг цэвэрлэсний дараа эвдэрсэн газрыг “Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн ерөнхий шаардлага MNS 5918:2008” стандартын дагуу нөхөн сэргээж байгалийн төрхөд аль болох ойртуулах
- Төслийн үйл ажиллагааны явцад үүссэн газрын гадаргын эвдрэлд өртсөн хэсгүүдэд ажлын явцад төрх байдлын сайжруулалт хийж, ухмал нүх овоолгыг тэгшилж байх.
- Маршрутын бус замаар бүтээгдэхүүн тээвэрлэхгүй байх
- Суурингийн талбайд хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд болон тухайн орчиндоо сөрөг нөлөөллийг бий болгох газар ашиглалтыг төлөвлөхгүй байх.
- Төслийн явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, зам тавих, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөд оруулдаг ч орчны тохижилт, ногоон байгууламжийг зохистой байршуулж асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Төслийн талбайн орчимд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулахдаа

зориулалтын хогийн цэг байгуулан асгаж байх шаардлагатай.

- Газрын хэвлийг төслийн хүрээнээс гадна аль болох бага хөндөх, ажил гүйцэтгэхэд ашиглах талбайг нөхөн сэргээх
- Ногоон байгууламж бий болгох.

5.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх
- Уурхайгаас гарах шороог төслийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай
- Төмрийн хүдэр тээвэрлэх машины зөөвөрлөх талбайд орох, гарах маршрутыг нарийвчлан тогтоох, олон салаа зам гаргахгүй байх, машин механизмын үзлэг үйлчилгээ хийх талбайг тогтоож, тэнд хөрс бохирдохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай
- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх
- Олборлолт дууссаны дараа уурхайд ашиглагдсан талбайг хэлбэршүүлэх, тэгшлэх, үржил шимт хөрсөөр хучих зэргээр техникийн нөхөн сэргээлт хийх
- Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх
- Уурхайн олборлолт, барилга байгууламж байгуулах явцад эвдэрсэн хөрсийг засаж тэгшлэх, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх
- Хөрс хадгалах зориулалттай талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэлд орох нөхцөлийг хамгийн бага байхаар төлөвлөх
- Шимт хөрсийг хамгаалахын тулд овоолгын өнгөн хэсгийг сэргээх, үүний тулд овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийх, тохиромжит ургамлын үр цацах, гадаргуугийн бүрхэвч бий болгох, хажуу бэлийг хамгаалах зорилгоор геоматериалаар хучих арга хэмжээ авах

5.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

- Төслийг хэрэгжүүлэхдээ Усны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24, 2, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.3, 30.1.4, 30.1.5, 30.2.2 дахь заалтуудын хэрэгжилтийг ханган ажиллахыг зөвлөж байна. Мөн уурхайн шүүрлийн усанд төлбөр ногдоно.
- Уурхайн хэрэгцээнд ашиглагдаж буй усыг зориулалтын дагуу ариг гамтай, хяналттай ашиглаж хэрэглэх, ашиглаж буй усны бүртгэл хөтлөх,
- Уурхайн хуурай, шингэн хог хаягдлыг хадгалах зөөврийн болон түр цэгүүдийг зохистой байршилд нь зөв байрлуулах, стандарт шаардлагын дагуу хийж (тоноглож) ашиглахын зэрэгцээ тэдгээрийн бүрэн бүтэн байдалд байнга хяналт тавьж ажиллах (“Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ахуйн бохир ус зайлуулах цэгээ ус тусгаарлагчаар тусгаарлаж тохижуулах журам”, Байгаль орчин, аялал

жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан 2018 оны 04 сарын 05 өдрийн А/82/128 тоот тушаалын хавсралт),

- Хуурай ба шингэн хог хаягдлыг зориулалтын бус газар асгаж, хаяхгүй байх нь хөрс, ус бохирдохоос хамгаалж, улмаар гадаргын болон газрын доорх усны нөөц бохирдох, чанар муудахаас сэргийлэх ба хог хаягдлыг зөөж тээвэрлэх эрх бүхий орон нутгийн зохих байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллах,
- Уурхай орчмын бүс нутгийн газрын доорх усны түвшний бууралт, нөөц багасалт болон усны чанарт хяналт тавих үүднээс мониторингийн цэгүүдийг зөв тогтоож, хяналт шинжилгээг байнга хийх (уурхайн дээд болон доод /мөн баруун, зүүн/ талд орших худаг, уст цэгүүдэд орчны хяналт шинжилгээг хийнэ. Ашиглалтын худаг, цооногуудыг бас хамруулна),
- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллана.
- Ажилчид болон төслийн талбай түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн унд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэх эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.
- Бага оврын цэвэрлэх байгууламжийг суурилуулж ашигласан бохир усыг цэвэршүүлэн тоосжилт дарах усалгаанд ашиглах
- Уурхайн унд ахуй, тоосжилт дарах хэрэгцээнд ашиглагдаж буй усыг зориулалтын дагуу ариг гамтай, хяналттай ашиглаж хэрэглэх, ашиглаж буй усны бүртгэл хөтлөх,
- Хуурай ба шингэн хог хаягдлыг зориулалтын бус газар асгаж, хаяхгүй байх нь хөрс, ус бохирдохоос хамгаалж, улмаар гадаргын болон газрын доорх усны нөөц бохирдох, чанар муудахаас сэргийлэх ба хог хаягдлыг зөөж тээвэрлэх эрх бүхий орон нутгийн зохих байгууллагатай хамтран ажиллах гэрээг байгуулан ажиллах,

5.5 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

- Ил уурхай нь зөвхөн ашиглалт явуулж буй талбайд бус түүний эргэн тойрныг хамарсан радиуст нөлөөлөл үзүүлж байдаг. Иймд уурхай орчмын амьтдын тоо толгой, байршил, шилжилт хөдөлгөөн, тэдгээрийн төрөл зүйл устах болон амьдралынх нь хэвийн үйл ажиллагаа алдагдаж буй эсэхэд мониторинг судалгаа хийх, хамгаалах төлөвлөгөө боловсруулах, хариу арга хэмжээ авах.
- Тухайн бүс нутгийн биологийн олон янз байдлын мониторинг судалгаа, хамгаалалд орон нутгийн захиргаа, байгаль орчны хэлтэс, мэргэжилтэн, байгаль хамгаалагч, эрдэмтэн судлаачидтай хамтран ажиллах.
- Дуу чимээний нөлөөгөөр амьтад үргэж дайжин биологийн олон янз байдалд шууд нөлөөлдөг тул уурхай орчимд мод бут тарьж дуу чимээний хязгаарлалт хийх, дуу чимээ бага гаргадаг, техникийн үзүүлэлт сайтай тоног төхөөрөмж ашиглах.
- Тоосжилтыг бууруулж хуурайшилт ихтэй үед зам талбайг услах.
- Үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг байгаль орчин болон зэрлэг амьтдад сөрөг нөлөөгүйгээр зохицуулах, хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн цэгт, шингэн хаягдлыг ил задгай хаяхгүй бохирын цооногт зайлуулах.
- Барилга баригдах талбай болон олборлолт явуулж буй талбайд хаалт хашилт хийж мал, амьтан орохоос хамгаалах, хязгаарлалт хийх

- Хөрс болон усан орчинд химийн бодис, тослох материал алдагдсан тохиолдолд тухайн бодисыг цаашид тархахаас нь сэргийлж, шингээн авах шаардлагатай. Ямар бодис алдагдсанаас шалтгаалан шингээж авах материалын нэр төрөл өөрчлөгдөх ба голдуу шингээгч инерт, саармаг материал, элс, шороо зэрэг материалуудыг ашиглах.
- Хуурайшилттай хавар, намрын улиралд хээрийн түймэр гарахаас сэргийлэх, түр болон байнгын ажилчдыг мэдээллээр хангах
- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэж байгаа усан сан, нүх, цооногуудыг богино хугацаанд нөхөн сэргээх, хамгаалалтын хайс татах зэрэг болно.

5.6 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Жил бүр ургамлын мониторинг судалгааг явуулах
- Ашиглалтын талбайн ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, маршрутын зам гаргах
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хогийн нэгдсэн цэг байгуулах, хогийг орчиндоо тархахааргүй байх талаар арга хэмжээ авах
- Ашиглалтын талбайн 20 хувьд ногоон байгууламж бий болгох
- Эвдрэлд өртсөн нийт талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх
- Тоосжилтын хэмжээг бага байлгах, эвдрэлд өртсөн зам талбайг усаар шүршиж чийглэх, төмрийн хүдэр болон хаягдлын овоолгын гадна талаар салхины үйлчлэлийг бууруулах хашаа барих
- Төслийн хугацаанд үйлдвэрийн үйл ажиллагаа, хүдэр тээвэрлэлтийн үед нарийн ширхэгт тоосонцор ургамлан нөмрөгийн фотосинтезид нөлөөлөх тул тоосжилтыг бууруулах, усны машин ашиглах
- Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртсөн талбайд биологийн нөхөн сэргээлт хийх
- Төслийн талбай, түүний орчны ургамлан нөмрөгт хяналт мониторинг хийж байх

5.7 Төслөөс нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зөвлөмж

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулал олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрд нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

5.8 Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах зөвлөмж

- Ажил эхлэхийн өмнө ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, гэнэтийн осол гамшгаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны самбар ажиллуулах, ажлын хувцсаар хангаж, галын хортой ажиллах

заавар өгч, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх буланг байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байх ёстой

- Уурхайн ажиллагсдад тусгай зориулалт бүхий амны хаалт, хувцас хэрэгсэл олгох.
- Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргах
- Орон сууц, хоолны газар, ажлын байрны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах
- Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах ажиллагсдад зориулалтын чихний бөглөө олгох
- Эмнэлгийн анхны тусламж үзүүлэх багаж хэрэгслийг ажлын байруудад зохих шаардлагын дагуу бэлтгэж байрлуулах
- Уурхайн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, аврах багийн хүрээнд сургалтад хамруулах
- Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл аюулгүй байдлыг хангах үүднээс цэвэрлэх байгууламжийн бохирын танканд сар бүр хуваарийн дагуу ариутгал, халдваргүйжүүлэлт хийх.
- Уурхайн тоног төхөөрөмж, ахуйн хаягдал цэг, сав агуулахуудын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, амрах бүх нөхцөлийг хангах зорилгоор зөв байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

Хүснэгт 8. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Агаарын чанар	Тоосжилтыг бууруулах замаар уурхай орчмын технологийн замыг хуваарийн дагуу усалж, тэгшлэн засч сайжруулж арчилж байх	Уурхайн бүсэд	Тухай бүр	Хуваарийн дагуу	Дотоод зардал	Дотоод зардал	III-р улиралд багтаан	MNS3113:1981 “Агаар мандлын бохирдлыг хэмжих аргачлалын ерөнхий шаардлага”
2		Уурхайн техник, хэрэгслийн үзлэг оношилгоонд хамруулах	Уурхайн техник хэрэгсэл	Жилд	1 удаа	1,300,000	1,300,000	IV-р улиралд багтаан	MNS3384:1982 “Агаар мандал-Агаарын дээжлэлт шинжилгээ”
3		Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдох агаарын бохирдлын төлбөрийг төлөх	Уурхайн бүсэд	ш	1	300,000	300,000	IV-р улиралд багтаан	MNS ISO4227-2002 “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө”
4		Тээвэрлэлтийн үед хурдны хязгаар тогтоох (40 км/цагаас хэтрэхгүй байх), тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, цаашид засаж сайжруулах	Уурхайн бүсэд	ш	1	200,000	200,000	IV-р улиралд багтаан	MNS4585-2016 “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008 “Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх

									хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага”
4	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Усны эх үүсвэрүүдийг тоолууржуулах	Гүний худаг	Сар бүр	1	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт /Усны нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг тогтоох, хөнгөлөх тухай/, MNS 13.06050 Усны чанарын стандарт, MNS 3342:1982 Газар доорх усыг бохирдлоос хамгаалах
5		Ус ашиглалтын дүгнэлт гаргуулан, ус ашиглуулах гэрээг холбогдох байгууллагатай хийх	Уурхайн бүсэд	-	Тухай бүр	1,000,000	1,000,000	IV-р улиралд багтаан	
6		Хаягдал ус хаях, зайлуулах дүгнэлт гаргуулах, хаягдал усны зөвшөөрөл авах, төлбөр төвлөрүүлэх	Төслийн талбайд	-	Тухай бүр	1,000,000	1,000,000	IV-р улиралд багтаан	
7		Гүний худгийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах, орчмын цэвэрлэгээ хийх	Төслийн талбайд	Жилд	2 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	6, 12 сард	
8	Хөрсөн бүрхэвч	Олборлолт нэмэгдэх бүрд шимт хөрсийг хуулж, тусгай талбайд стандартын дагуу байршуулж, хэлбэржүүлж хамгаалах	Төслийн талбайд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт Техникийн шаардлага MNS
9		Асгарсан тос масло хөрс бохирдуулагч аливаа бодис асгарсан тохиолдолд гүнд нэвчихээс сэргийлэх арга хэмжээ авах,	Засварын хэсэг	-	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	III-р улиралд багтаан	

		саармагжуулах талбайг гаргах							5915:2008, Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах Техникийн шаардлага MNS 5916:2008
10		Уурхайгаас УБ хот хүрэх гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, сайжруулсан зам болгох, цаашид арчилж тордох	Уурхайн нийт талбайд	-	Хуваарийн дагуу	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
11	Амьтны аймаг	Уурхайн нөлөөллийн бүсэд үзэгдэх, дайрч өнгөрөх ан амьтдын бүртгэл хийх баримтжуулах	Төслийн талбайн хүрээнд	-	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	Жилийн турш	Амьтны тухай хууль
12		Уурхайн эдэлбэрээс бусад эрүүл талбайд газар ухаж, амьтдын үүр нүх сүйтгэхгүй байх арга хэмжээ авах	Төслийн талбайн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	Жилийн турш	
Нийт							3,800,000		

БҮЛЭГ VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Байгаль орчин, геологи уул уурхайн хууль тогтоомжийн эмхэтгэл”, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад хууль, тогтоомж, зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа аж ахуй нэгж байгууллага Монгол улсын стандартын дагуу зайлшгүй хийсэн байх үүрэгтэй.

Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны 2022 оны тайлангаар уурхай орчмын нөлөөлөлд өртөх талбайг тогтоосон. Ил уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газарт дотоод овоолго, биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн.

Хүснэгт 9. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
2.Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө									
1	Биологийн нөхөн сэргээлт	Биологийн нөхөн сэргээлт хийх	Төслийн талбайд	га	0,5	2,000,000	2,000,000	IV-р улиралд багтаан	MNS5917-2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS5918-2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага Монгол улсын MNS 6253-252011 дагуу мод сөөг тарих, Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйл Байгаль орчиныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл
2	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд уурхайн кемп орчимоор мод тарих /Орон нутгийн тарьц, суулгацаар /	Уурхайн бүсэд	ш	400	1,400,000	1,400,000	5,10-р сард	
3		Тэрбум модны үндэсний хөтөлбөрийн хүрээнд таригдсан модонд нөхөн тарилт хийх	Уурхайн талбайд	ш	100	350,000	350,000	10-р сард	
Нийт							3,750,000		

БҮЛЭГ VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны “Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ”-нд тусгах ажлын саналыг Төв аймгийн БОАЖ-ын газрын саналыг үндэслэн тухайн газартай экологийн хувьд төстэй тус сумын нутаг дэвсгэрт дүйцүүлэн хамгаалах газар нутгийг сонгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэхээр төлөвлөж байна.

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө									
1	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Төв аймгийн Баянжаргалан сумын нутагт	БОАЖГазрын заасан газар нутагт хэрэгжүүлнэ	га	-	Дотоод зардал	Дотоод зардал	III-р улиралд багтаан	MNS5917-2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, MNS5918-2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах техникийн шаардлага
Нийт							-		

БҮЛЭГ VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

БҮЛЭГ IX. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны үед газар дээр ямар нэг таних тэмдэггүй дурсгал илэрвэл төсөл хэрэгжүүлэгч ажлаа зогсоон энэ тухай орон нутгийн Засаг дарга, цагдаагийн байгууллага болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ. Иймд түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний ажлыг төлөвлөгөөгүй болно.

БҮЛЭГ X. ОСОЛ, ЭРСДЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт 11. Болзошгүй эрсдлээс хамгаалах төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө									
1	Болзошгүй гэнэтийн аюул осол, байгалийн давагдашгүй хүчин зүйл	Уурхайн талбайд орон тооны бус аврах багийг бүрдүүлж сургалт зохион байгуулах	Уурхайн бүсэд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	7-р сард	ОБЕГ-ын даргын 2016 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөө
2	Хүний эрүүл мэнд, байгаль орчинд	Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргах	Гэрээ байгуулан ажиллах	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	

3	үзүүлж болох нөлөөлөл	Галын болон байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн нийт талбайд	Жилд	1 удаа	200,000	200,000	III-р улиралд багтаан	боловсруулах заавар”
4		Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх	Уурхайн талбайд	Жилд	1 удаа	600,000	600,000	II-р улиралд багтаан	
Нийт						800,000			

БҮЛЭГ XI. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд Монгол улсын хууль болон стандартуудыг баримтална. Төслөөс энэхүү үүргүүдээ биелүүлэхдээ эцсийн байдлаар үүсэх хог хаягдлын хэмжээг бууруулах үүднээс хийсэн менежментийн сонголтыг үнэлж дүгнэх арга барилыг хэрэгжүүлэх шаардлагатай.

Хүснэгт 12. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө									
1	Ахуйн	Хог хаягдлыг түр цэгт хадгалах, ангилан ялгаж байршуулах, хог хаягдлыг	Уурхайн нийт талбайд	-	Тухай бүрт	1,200,000	1,200,000	IV-р улиралд багтаан	Хог хаягдлын тухай хууль болон

		сумын нэгдсэн цэгт тээвэрлэх, баталгаажуулах							холбогдох журам, заалтууд Хог хаягдлын тухай хуулийн 14-р Зүйл, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
2		Хог хаягдлыг батлагдсан маягтаар эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалтын дагуу ангилан ялгах	Төслийн хүрээнд	-	Тухай бүрт	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
3	Аюултай	Тос, тослох материалын сав, арчсан материал хэрэгслийг аюултай хог хадгалах байранд түр хуримтлуулах	Төслийн хүрээнд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	IV-р улиралд багтаан	
4		Асгаралт үүсэхээс сэргийлж тогтмол хяналт тавих, үзлэг шалгалт явуулах, асгаралт үүссэн тохиолдолд бүртгэлжүүлэх, саармагжуулах талбайд хуримтлуулах	Уурхайн нөлөөлийн бүс	-	Тухай бүр	Дотоод зардал	Дотоод зардал	2025 онд	
5		Ажилчдад аюултай хог хаягдлын талаар сэдэвчилсэн сургалт орох	Уурхайн талбайд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	2025 онд	
6		Аюултай хог хаягдлыг ангилан бүртгэлжүүлж, хэмжээг гаргах	Уурхайн талбайд	Жилд	1 удаа	Дотоод зардал	Дотоод зардал	2025 онд	
7	Үйлдвэрийн	Хатуу хог хаягдлыг ангилан хурааж дахин ашиглах, хашааг янзлах	Төслийн талбайд	-	Тухай бүрт	Дотоод зардал	Дотоод зардал	2025 онд	
Нийт							1,200,000		

БҮЛЭГ XII. ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Эрдэнэмайнинг Үйлс” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Хүснэгт 13. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн төлөвлөгөө

№	Хяналт шинжилгээ	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр									
1	Ус	Усны хими,микробиологи, хүнд металлын шинжилгээг өгөх	Гүний худагт	жилд	2 удаа	383,000	766,000	IV-р улиралд багтаан	MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000
2		Унд ахуйн усны шинжилгээг өгөх	Гал тогоо	жилд	1 удаа	200,000	200,000	IV-р улиралд багтаан	
3	Хөрс	Хөрсний шинжилгээ /Хөрсний чанар хими физикийн ерөнхий үзүүлэлт, хүнд металл/	Хяналтын 4 цэгт	жилд	1 удаа	310,000	310,000	IV-р улиралд багтаан	Гадаад орчны уснаас сорьц авах болон тээвэрлэх, гарын авлагын зөвлөмж MNS 13.060.50 Усны чанарын стандарт , MNS 0900 : 2005 Ундны ус.
4	Агаарын найрлага	Агаарын чанарын хяналт шинжилгээ /тоос,дуу шуугиан, найрлага,доргио чичиргээ/	Агаарын дээж авах 3 цэгт	жилд	1 удаа	300,000	300,000	IV-р улиралд багтаан	

									Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад MNS 4585:2016 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
Нийт						1,576,000			

БҮЛЭГ XIII. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны мэргэжилтэн ажиллуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээг авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

Хүснэгт 14. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар	Сар	Сар		
	1	2	3	4	5	6	7
1	БОМТөлөвлөгөөний хэрэгжилтийг шалгах улсын комиссыг ажиллуулах	1,000,000	Жилд 1 удаа	-	-	Компанийн удирдлагууд	Төлөвлөсөн газарт
2	Байгаль хамгаалах хавар, намрын сарын аян хүрээнд сургалт мэдээлэл ажилчдад өгөх	Дотоод зардал	Жилд 1 удаа	-	-	БОМэргэжилтэн	
Нийт зардал		1,000,000	-	-	-		

БҮЛЭГ XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖИЛТИЙН НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

“Эрдэнэмайнинг Үйлс” ХХК -ийн төмрийн хүдрийн ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд **13,126,000 мян.төг** зарцуулахаар төлөвлөлөө.

Хүснэгт 15. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

БОМТ-ний биелэлтийг тайлагнахад	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилта	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Улс, аймгийн хэмжээнд	Проектор танилцуулга	БОМТ-ний 2025 оны тайлангийн танилцуулга	Жилд	500,000	БОМэргэжилтэн	БОАЖ-ын яам eic.mn
Сум, орон нутаг, багийн хэмжээнд	Проектор танилцуулга	БОМТ-ний 2025 оны тайлангийн танилцуулга	2025 онд	500,000	БОМэргэжилтэн	Орон нутагт
Нийт				1000,000		